



Хүмүүстэй харилцах чадвар

## Мэргэжлийн бөгөөд эелдэг харилцах нь

### Удиртгал

Энэхүү сургалт нь ажил хэрэгч, эелдэг харилцаагаар дамжуулан үр дүнд чиглэсэн, хамтын ажиллагааг бий болгоход тусална. Харилцаан дээр бусдыг гомдоохгүйгээр, бусадтай зөрчилдөхгүйгээр эерэг үр дүнд хэрхэн хүрч болохыг та харах болно. Ажил хэрэгч харилцааны үр чадвар нь зөвхөн таны мэргэжлийн дүр төрхийг сайжруулаад зогсохгүй, бусдад үлгэр дуурайл болохуйц өндөр нөлөөлөлтэй.

### Сургалтын агуулга

Бид ямар ч нөхцөлд хэзээ юуг хэрхэн хэлэхээ мэддэг хүмүүсийг хараад биширдэг. Энэ хүмүүс мэргэжлийн бөгөөд эелдэг харилцахыг мэддэг хүмүүс юм.

Mike Posey-ын ZERORISK HR судалгаанд дурдсанаар сэтгэл хөдлөлийн 5 үр чадварын нэгд амжилттай удирдагчид “харилцааны чадвар ба төвт байдлыг” ашиглаж чаддаг.

Мэргэжлийн бөгөөд эелдэг харилцах нь танд өөрчлөлтийг удирдаж, тохиролцож, дунджийг баримтлах, зөрчлийг удирдах, бусадтай хамтрах, идэвхтэй баг бий болгоход тусалж, манлайллын чадвараа сайжруулахад тусална.

### Ямар үр дүнд хүрэх вэ?

- Хүнд хэцүү нөхцөл байдалд өөртөө итгэлтэй, эелдэг, мэргэжлийн харилцаж сурах
- Сөрөг сэтгэл хөдлөл илэрхийлэхгүйгээр санал хүсэлт хүлээн авч, бусдад санал хүсэлт өгч сурах

### Ямар үр чадвар эзэмших вэ?

#### Үндсэн үр чадварууд

**Харилцааны чадвар** - Мэдээллийг идэвхтэй сонсож суралцах

**Ажил хэрэгч байдал** - Таныг итгэл даах чадварыг илэрхийлэх өөртөө итгэлтэй, шударга, ёс суртахуунтай имиж бүрдүүлэхэд суралцах

**Хүмүүс хоорондын харилцаа** - Байгууллагын дотор болон гадна урт богино хугацааны харилцааг бий болгож суралцах. Сөрөг, ялгаатай үзэл бодолд дунджийг баримтлах арга техникт суралцах

---

#### Бусад үр чадварууд

**Зөрчлийг удирдах** - Стресстэй харилцааны нөхцөлд тайван байж, ялгаатай байдлаас үүдэн зөрчилтэй тулгарч буй хүмүүсийг нэгтгэх

**Өөр өнцгөөс харах** - Бусдын ялгаатай үзэл бодлыг өөр өнцгөөс харж, бусдад үзүүлэх нөлөөг таних